МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны төрөл:	**Лавлагаа мэдээлэл**
Судалгааны код:	**СТ-25/239**
Огноо:	2025.10.01

ЗАХИАЛАГЧ:	УИХ-ын гишүүн О.Номинчимэг
Хянасан:	ПСХХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт ПСХХ-ийн Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр
Судалгаа удирдсан:	ПСХХ-ийн Судалгааны хэлтсийн зөвлөх Г.Билгээ
Судлаач:	М.Нямжаргал

Улаанбаатар хот
2025

АГУУЛГЫН ТОВЬЁГ

УДИРТГАЛ 2

НЭГ. ПАРЛАМЕНТ ДАХЬ ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО, ТҮҮНИЙ ЭРХЛЭХ АСУУДАЛ БА БҮРЭЛДЭХҮҮН 3

1.1. Өргөдлийн байнгын хороог байгуулах нь 3

1.1.1. Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим) 3
1.1.2. Их Британи Улс (Нийтийн Танхим) 3
1.1.3. Герман Улс (Бундестаг) 4
1.1.4. Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс) 5
1.1.5. Европын Холбоо (Европын Парламент) 5

1.2. Байнгын хорооны эрх, үүрэг 5

1.2.1. Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим) 5
1.2.2. Их Британи Улс (Нийтийн Танхим) 6
1.2.3. Герман Улс (Бундестаг) 6
1.2.4. Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс) 7
1.2.5. Европын Холбоо (Европын Парламент) 7

1.3. Байнгын хорооны бүрэлдэхүүн 7

1.3.1. Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим) 7
1.3.2. Их Британи Улс (Нийтийн Танхим) 7
1.3.3. Герман Улс (Бундестаг) 8
1.3.4. Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс) 8
1.3.5. Европын Холбоо (Европын Парламент) 8

ХОЁР. ӨРГӨДӨЛ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦ БА ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ 9

2.1. Өргөдлийн төрөл, түүнд тавигдах шаардлага 9

2.1.1. Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим) 9
2.1.2. Их Британи Улс (Нийтийн Танхим) 9
2.1.3. Герман Улс (Бундестаг) 10
2.1.4. Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс) 11
2.1.5. Европын Холбоо (Европын Парламент) 11

2.2. Өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх үйл явц 12

2.2.1. Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим) 12
2.2.2. Их Британи Улс (Нийтийн Танхим) 12
2.2.3. Герман Улс (Бундестаг) 13
2.2.4. Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс) 14
2.2.5. Европын Холбоо (Европын Парламент) 14

2.3. Олон нийтийн оролцоог хангах 16

2.3.1. Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим) 16
2.3.2. Их Британи Улс (Нийтийн Танхим) 16
2.3.3. Герман Улс (Бундестаг) 16
2.3.4. Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс) 17
2.3.5. Европын Холбоо (Европын Парламент) 17

ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН 18

НОМ ЗҮЙ 20

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн УИХ-03/9396 дугаартай албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу “Парламент дахь өргөдлийн байнгын хороо”-ны талаарх судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Гадаад улс орнуудын парламент дахь өргөдлийн байнгын хорооны талаарх хууль, эрх зүйн онцлог зохицуулалтыг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд өргөдлийн байнгын хороо байгуулан ажиллуулдаг дараах улсуудын парламентын зохицуулалт хамрагдана. Үүнд: Австралийн Холбооны Улс (Австрали Улс), Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (Их Британи Улс), Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (Герман Улс), Испанийн Хаант Улс (Испани Улс), Европын Холбоог харуулсан болно.

Эдгээр улсуудын парламент дахь өргөдлийн байнгын хорооны бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх хэмжээ, хариуцдаг асуудлын хүрээ, өргөдөл шийдвэрлэх арга зүй, иргэдийн оролцоог хангах механизмын талаар харьцуулсан судалгаа хийсэн.

Нэршлийн тайлбар: Судалгаанд хамрагдсан улсуудын парламентын бүтэц, дэгд өргөдлийн асуудлыг хянан шийдвэрлэхэд үүрэг гүйцэтгэдэг хороодын албан ёсны нэршил нь харилцан адилгүй байна. Жишээлбэл, Австрали Улсад - Standing Committee on Petitions, Герман Улсад - Petitionsausschuss, Их Британи Улсад - Petitions Committee, Испани Улсад - Comisión de Peticiones, Европын Парламентын хувьд Committee on Petitions гэх мэтээр нэрлэдэг. Энэхүү судалгаанд ойлгомж, нэг мөр байдлыг хангах үүднээс дээрх бүх нэршлийг “Өргөдлийн байнгын хороо” гэж нэг мөр хэрэглэв.

Судалгааны ажлын бүтэц: Судалгааны тайлан үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ:

1. Парламент дахь өргөдлийн байнгын хороо, түүний эрхлэх асуудал ба бүрэлдэхүүн
    1.1. Байнгын хороог байгуулах эрх зүйн үндэс
    1.2. Байнгын хорооны эрх, үүрэг
    1.3. Байнгын хорооны бүрэлдэхүүн
2. Өргөдөл шийдвэрлэх үйл явц ба олон нийтийн оролцоог хангах
    2.1. Өргөдлийн төрөл, түүнд тавигдах шаардлага
    2.2. Өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх үйл явц
    2.3. Олон нийтийн оролцоог хангах

Судалгааны арга зүй: Судалгааг тухайн улсын холбогдох хууль тогтоомж, парламентын дэг, эрх зүйн зохицуулалтад тулгуурлан харьцуулсан шинжилгээ, нэгтгэн дүгнэх аргаар боловсруулав.

Түлхүүр үг:

Монгол: Өргөдлийн байнгын хороо, өргөдөл шийдвэрлэх үйл явц, иргэдийн оролцоо.

Англи: Standing committee on petitions, petitions committee, petition procedures, citizen participation.

НЭГ. ПАРЛАМЕНТ ДАХЬ ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО, ТҮҮНИЙ ЭРХЛЭХ АСУУДАЛ БА БҮРЭЛДЭХҮҮН

1.1. Өргөдлийн байнгын хороог байгуулах нь

Энэхүү хэсэгт судалгаанд хамрагдсан таван улсын тогтолцоонд Өргөдлийн байнгын хороо ямар эрх зүйн үндсэн дээр байгуулагдсаныг судалж, хууль тогтоомжийн түвшинд эрхийг баталгаажуулсан байдал болон парламентын дэг, практикт тулгуурласан тогтолцоог харьцуулна. Улс бүрээр хороог байгуулсан эрх зүйн баримт бичиг, аль танхимд байршдаг, байгуулсан үеийн зорилго болон тус хороотой холбоотой гол шинэчлэлийг тэмдэглэнэ. (Нэр томьёоны нэг мөр байдлын үүднээс эдгээр байгууллагуудыг “Өргөдлийн байнгын хороо” хэмээнэ (шаардлагатай тохиолдолд албан ёсны нэршлийг хавсаргана).)

1.1.1. Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим)

Австрали Улсын Парламент дахь өргөдлийн тогтолцоо нь иргэдийн санал хүсэлтийг парламенттай шууд холбох уламжлалт хэлбэр байсан боловч олон жилийн турш идэвх султай хэрэгжиж, бодит нөлөө нь харьцангуй хязгаарлагдмал байжээ (Australian Parliament, 2025-1). Түүнчлэн өргөдөл гаргах эрх нь тус улсын Үндсэн хуульд тусгагдаагүй, харин Парламентын хоёр танхимын дэг, уламжлалын хүрээнд хэрэгждэг онцлогтой (Parliamentary Education Office, n.d.).

Энэ байдлыг өөрчлөхийн тулд 2007-2008 онд Төлөөлөгчдийн Танхимын Дэгийн байнгын хороо өргөдлийн тогтолцооны талаарх судалгааг явуулж, “*Өөрчлөлт хийх нь: Төлөөлөгчдийн Танхимын өргөдлийн тогтолцоо” (Making a difference: Petitioning the House of Representatives)* хэмээх тайланг гаргасан байна. Уг тайланд өргөдлийн эрхийг бодитоор хэрэгжүүлэхийн тулд тусгай байнгын хороо байгуулах санал дэвшүүлсний үндсэн дээр 2008 онд Төлөөлөгчдийн Танхимын Өргөдлийн байнгын хороо (ӨБХ) албан ёсоор байгуулагджээ (Australian Parliament, 2025-1).

Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэгд[1] ӨБХ-ны чиг үүрэг, бүрэлдэхүүнийг тодорхойлсон байдаг. Мөн өргөдлийн хэлбэрт тавигдах шаардлага (§204-205), цахим өргөдлийн журам (§205A), өргөдлийг Төлөөлөгчдийн Танхимд танилцуулах болон хянан шийдвэрлэх журам (§206-208), холбогдох яаманд шилжүүлж, хариу авах зохицуулалт (§209) тусгагдсан байна.

1.1.2. Их Британи Улс (Нийтийн Танхим)

Их Британи Улсад иргэдийн өргөдөл гаргах эрхийг анх 1689 оны ***Эрхийн тунхаг*** (Bill of Rights)-д “харьяат хаандаа өргөдөл гаргах эрхтэй” гэж заан өргөдөл гаргах эрхийг баталгаажуулжээ. Энэ нь парламентын эх сурвалжид тодорхой дурдагддаг бөгөөд уг хуульд “иргэд өргөдөл гаргах эрхтэй бөгөөд эрхээ хэрэгжүүлсний төлөө шийтгэх ёсгүй” гэсэн заалт орсон байдаг (UK Parliament, n.d.). Парламентын түвшинд хэрхэн өргөн мэдүүлэх, хэлэлцэх журмыг ***Нийтийн Танхимын хуралдааны дэгд***[2] нарийвчлан зохицуулдаг.

---

[1] Австрали Улс. Standing and Sessional Orders (2004) [2025]. Хандах: *https://www.aph.gov.au/-/media/05_About_Parliament/53_HoR/532_PPP/Standing_Orders/SOs_as_at_23_July_2025.pdf*

[2] Их Британи Улс. Standing Orders of the House of Commons (2018). Хандах: *https://publications.parliament.uk/pa/cm5901/cmstords/so_829_05072024/so-2024i.pdf*

2015 онд Нийтийн Танхимын Дэгийн байнгын хорооноос гаргасан *“Цахим өргөдөл: хамтын ажиллагаанд суурилсан тогтолцоо” (E-petitions: a collaborative system)* хэмээх тайланд цаасан болон цахим өргөдлийн системийг нэгтгэхийг санал болгосон. Ийнхүү нэг платформд нэгтгэх нь олон нийтэд өргөдлийн үйл явцыг илүү ойлгомжтой, хүртээмжтэй болгох зорилготой байв (UK Parliament, 2015).

Үүний үндсэн дээр 2015 оны 7 дугаар сард Нийтийн Танхимын хуралдааны дагуу Өргөдлийн байнгын хороо (ӨБХ) байгуулагдсан байна (§122B(1)(c)). ӨБХ нь цахим болон цаасан өргөдлүүдийг нэгтгэн хянан шийдвэрлэх, зарим өргөдлийг Вестминстерийн танхим (Westminster Hall)-д хэлэлцүүлэх үүрэгтэй (Erskine May, 2019).

Дэгд ӨБХ-ны чиг үүрэг, бүрэлдэхүүнийг (§145A), өргөдлийг хүлээн авах, танилцуулах, албан тэмдэглэлд нийтлэх журмыг (§153; 156), мөн Вестминстерийн танхимд өргөдлийн хэлэлцүүлгийн цагийн зохицуулалтыг (§10; 14) нарийвчлан тусгасан байдаг.

1.1.3. Герман Улс (Бундестаг)

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс 1949 онд байгуулагдсан цагаас эхлэн Өргөдлийн байнгын хороо нь Бундестаг болон иргэдийн хоорондын гол холбоосын үүргийг гүйцэтгэж ирсэн (German Bundestag, n.d.-1); (German Bundestag, n.d.-2).

ӨБХ-ны эрх зүйн үндсийг хэд хэдэн хуулиар тогтоосон байдаг. Юуны өмнө ***Үндсэн хуулийн***[3] 17 дугаар зүйлд хүн бүр ганцаараа, эсхүл бусадтай хамтран хүсэлт, гомдлоо эрх бүхий байгууллага болон хууль тогтоох байгууллагад гаргах эрхтэйг заасан бөгөөд энэ нь иргэншил болон оршин суух байршлаас үл хамаарна. Үүнтэй уялдан Бундестаг нь өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх үүрэг бүхий Өргөдлийн байнгын хороо (ӨБХ)-г байгуулж, бүрэн эрхийг нь холбооны хуулиар тогтоосон (§45c).

Энэхүү зохицуулалтын дагуу батлагдсан ***Өргөдлийн байнгын хорооны бүрэн эрхийн тухай хуулиар***[4] өргөдөл, гомдлыг хүлээн авч судлах, баримт цуглуулах, мэдээлэл шаардах, өргөдөл гаргагч, гэрч, шинжээчийг сонсох, тайлан боловсруулж танилцуулах зэрэг чиг үүргийг нарийвчлан тогтоосон.

Мөн ***Бундестагийн хуралдааны дэгт***[5] ӨБХ-ны үйл ажиллагааны дараах журам тусгагдсан байдаг. Үүнд: өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх (§108), бусад хороонд шилжүүлэх (§109), мэдээлэл болон баримт бичиг шаардах, өргөдөл гаргагч, гэрч, шинжээчийг сонсох (§110), зарим бүрэн эрхээ гишүүддээ шилжүүлэх (§111), зөвлөмж, тайлангаа танилцуулах (§112).

Түүнчлэн ***“Өргөдлийн байнгын хорооны хүсэлт, гомдлыг шийдвэрлэхэд бариmтлах зарчим (Процессын зарчим)”***[6]-д өргөдлийн төрөл, хэлбэрийн шаардлага, 50 мянгаас дээш дэмжлэгтэй өргөдлийг олон нийтийн сонсголд хэлэлцэх журам, мэдээлэл авах, өргөдөл гаргагч, гэрч, шинжээчийг дуудах, Бундестагт тайлагнах зэрэг зохицуулалтыг тусгасан байна.

---

[3] Герман Улс. Basic Law for the Federal Republic of Germany (1949). Хандах: https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html

[4] Герман Улс. Gesetz über die Befugnisse des Petitionsausschusses des Deutschen Bundestages, Gesetz nach Artikel 45c des Grundgesetzes (Act on the Powers of the Petitions Committee of the German Bundestag) (1975). Хандах: https://www.gesetze-im-internet.de/ggart45cg/BJNR019210975.html

[5] Герман Улс. Rules of Procedure of the German Bundestag (1951). Хандах: https://www.btg-bestellservice.de/pdf/80060000.pdf

[6] Герман Улс. Grundsätze des Petitionsausschusses über die Behandlung von Bitten und Beschwerden (Petitionen) (Principles of the Petitions Committee Governing the Treatment of requests and Complaint (Procedural Rules)) (2021). Хандах: https://www.landtag.sachsen.de/de/mitgestalten/petition/grundsaetze-des-petitionsausschusses-9213.cshtml

1.1.4. Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс)

Иргэдийн өргөдөл гаргах эрхийг 1978 онд батлагдсан Испани Улсын ***Үндсэн хуулийн***[7] 77 дугаар зүйлд баталгаажуулсан байдаг. Уг зүйлд иргэн болон холбоод нь Парламентын аль нэг танхим, төрийн байгууллагад бичгээр өргөдөл гаргах эрхтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд Парламент өргөдлийг Засгийн газарт шилжүүлж, Засгийн газар тайлбар өгөх үүрэгтэй гэж заасан байна.

Энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан ***Өргөдөл гаргах эрхийг зохицуулах хууль***[8] нь иргэн, бүлэг, холбоо, эсхүл хуулийн этгээд төрийн байгууллага болон эрх бүхий этгээдэд өргөдөл гаргах эрхтэй болохыг нарийвчлан тогтоосон байна (§1).

Энэ эрхийг хэрэгжүүлэх үндсэн механизм нь Төлөөлөгчдийн Конгрессын Өргөдлийн байнгын хороо (ӨБХ) бөгөөд тус хороог заавал байгуулах байнгын хороо хэмээн ***Конгрессын хуралдааны дэгд***[9] тусгайлан заасан байна (§46.2). Мөн дэгээр ӨБХ-ны бүрэлдэхүүн (§40-41), өргөдөл хүлээн авах, шилжүүлэх, хэрэгсэхгүй болгох болон өргөдөл гаргагчид мэдэгдэх журам (§44; §49)-ыг тодорхойлдог.

1.1.5. Европын Холбоо (Европын Парламент)

Европын Парламент 1970-1980-аад онд өргөдөл хүлээн авах журам тогтоосны үндсэн дээр 1987 онд Өргөдлийн байнгын хороо (ӨБХ)-г байгуулжээ. Иргэдийн өргөдөл гаргах эрхийг анх 1992 оны Маастрихтын гэрээгээр (Maastricht Treaty) Европын Холбооны иргэний үндсэн эрхийн нэг болгон баталгаажуулсан бөгөөд өнөөдөр энэ эрх нь Европын Холбооны Үйл ажиллагааны тухай гэрээ (Treaty on the Functioning)-ний 227 дугаар зүйл болон Европын Холбооны Үндсэн эрхийн харт (Charter of Fundamental Rights)-ын 44 дүгээр зүйлээр хамгаалдаг (European Parliament, 2025).

Европын Парламентын хуралдааны дэгийн[10] 6 дугаар хавсралтад ӨБХ нь байнгын хороодын нэг болохыг тодорхой зааснаас гадна өргөдлийг хүлээн авах, шалгах, олон нийтийн оролцоог хангах (§232-233), газар дээрх шалгалт явуулах (§234), өргөдлийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээх (§235), хэлэлцэх (§236) зэрэг эрх, үүрэг болон журмыг нарийвчлан зохицуулсан байдаг.

1.2. Байнгын хорооны эрх, үүрэг

1.2.1. Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим)

Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэгийн дагуу ӨБХ нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- өргөдөл хүлээн авч, түүнийг хэлэлцэх (§220(a));
- өргөдөл болон түүний системтэй холбоотой аливаа асуудлыг судлах (§220(a));
- өргөдлийн талаар Төлөөлөгчдийн Танхимд тайлагнах (§220(a));

---

[7] Испани Улс. Spanish Constitution (1978). Хандах: https://www.senado.es/web/conocersenado/normas/constitucion/detalleconstitucioncompleta/index.html?lang=en

[8] Испани Улс. Ley Orgánica 4/2001, de 12 de noviembre, reguladora del Derecho de Petición (Organic Law regulating the Right of Petition) (2001). Хандах: https://www.boe.es/buscar/act.php?id=BOE-A-2001-21090

[9] Испани Улс. Standing Orders of the Congress of Deputies (1982). Хандах: https://www.congreso.es/es/normas/reglamento-del-congreso

[10] Европын Холбоо. Rules of Procedure of the European Parliament. Хандах: https://www.europarl.europa.eu/doceo/document/RULES-10-2025-07-07-TOC_EN.html

- өргөдөлд Төлөөлөгчдийн Танхимын нэрийн өмнөөс албан ёсоор хариу өгөх (§208(e)).

1.2.2. Их Британи Улс (Нийтийн Танхим)

Нийтийн Танхимын хуралдааны дэгийн дагуу ӨБХ нь өргөдлийг хүлээн авах, хянан үзэх, судлах, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, Засгийн газар болон Парламентын түвшинд тайлагнах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Нийтийн Танхимд ирүүлсэн цаасан өргөдөл, мөн Парламент болон Засгийн газрын өргөдлийн цахим хуудас (petition.parliament.uk)-аар ирүүлсэн цахим өргөдлийг хүлээн авч хянан үзэх (§145A(1));
- холбогдох талууд (гэрч, холбогдох албан тушаалтан, мэргэжилтэн, өргөдөл гаргагч)-ыг сонсголд дуудах, бичиг баримт болон тэмдэглэл шаардах, газар дээр нь ажиллах, шаардлагатай үед тайлагнах (§145A(3); (5));
- дэд хороо байгуулах (дэд хороо нь гурван гишүүнтэй бөгөөд мөн адил холбогдох талуудаас мэдээлэл гаргуулах, бичиг баримт болон тэмдэглэл шаардах, тайлангаа ӨБХ-нд танилцуулах чиг үүрэгтэй (§145A(4); (6));
- өргөдлийг Вестминстерийн танхимд хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэж, шийдвэрээ Нийтийн Танхимд танилцуулах (§145A(7); 10(1)(a)).

1.2.3. Герман Улс (Бундестаг)

Бундестагийн хуралдааны дэг болон “Өргөдлийн байнгын хорооны хүсэлт, гомдлыг шийдвэрлэхэд баримтлах зарчим (Процессын зарчим)”-д зааснаар ӨБХ нь өргөдөл, гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэх, холбогдох байгууллагаас мэдээлэл шаардах, өргөдөл гаргагч болон шинжээчдийг сонсох, тайлан дүгнэлт гаргаж Бундестагт танилцуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- өргөдөл, гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэх (Дэгийн §108; Процессын зарчмын §1; 8);
- өргөдөлд тавигдах шаардлага хангагдаагүй, эсхүл хангалтгүй тохиолдолд хүлээн авахаас татгалзах (Процессын зарчмын §4; 7.3);
- өргөдлийг ӨБХ-нд шилжүүлэн авч хэлэлцэх, бусад байнгын хороодтой уялдуулах, шаардлагатай бол тэднээс санал авах (Дэгийн §109; Процессын зарчмын §6.3);
- мэдээлэл цуглуулах, сонсгол зохион байгуулах, холбооны яам, байгууллага болон бусад эрх бүхий байгууллагаас баримт бичиг, тайлбар шаардах, өргөдөл гаргагч, гэрч, шинжээчийг сонсох (Дэгийн §110; Процессын зарчмын §6.1);
- зарим бүрэн эрхээ нэг буюу хэд хэдэн гишүүндээ шилжүүлэх (Дэгийн §111; Процессын зарчмын §6.3);
- тайлан, зөвлөмж гаргах, сар бүр өргөдлийн шийдвэрийн жагсаалтыг, жил бүр үйл ажиллагааны тайланг Бундестагт танилцуулах, мөн өргөдөл гаргагчид болон олон нийтэд шийдвэрийн үр дүнг мэдэгдэх (Дэгийн §112; Процессын зарчмын §9; 11);
- шаардлагатай тохиолдолд өргөдлийн талаарх шийдвэрийн төслийг Бундестагт өргөн мэдүүлэх (Процессын зарчмын §6.3).

1.2.4. Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс)

Төлөөлөгчдийн Конгрессын хуралдааны дэгд зааснаар ӨБХ дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Төлөөлөгчдийн Конгресст ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгах (§49.2);
- шаардлагатай гэж үзвэл Төлөөлөгчдийн Конгрессын даргаар дамжуулан өргөдлийг дараах байгууллагад шилжүүлэх шийдвэр гаргах (§49.2):
    - Ард түмний өмгөөлөгч буюу Омбудсменд (the Defender of the People);
    - тухайн асуудлыг хэлэлцэж буй Төлөөлөгчдийн Конгрессын өөр байнгын хороонд;
    - Сенат, Засгийн газар, Шүүх, Прокурорын алба, өөртөө засах нийгэмлэг, аймгийн зөвлөл, Канарын арлын зөвлөл (Cabildo), эсхүл хотын зөвлөлд;
- хэрэв дээрх байгууллагад шилжүүлэх нь зохимжгүй гэж үзвэл өргөдлийг цаашид хэлэлцэхгүйгээр хэрэгсэхгүйд тооцох (§49.3);
- өргөдөл хүлээн авсныг баталгаажуулж, гаргасан шийдвэрийн талаар өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэх (§49.4);
- Засгийн газар болон төрийн байгууллагаас мэдээлэл, баримт бичиг шаардах, холбогдох сайд, төрийн албан тушаалтан, шинжээчийг дуудах эрхтэй (§44).

1.2.5. Европын Холбоо (Европын Парламент)

Европын Парламентын хуралдааны дэгийн дагуу ӨБХ дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- өргөдлийг хүлээн авч, хамааралтай эсэхийг шалган тогтоох (§232-233);
- шаардлагатай тохиолдолд баримт цуглуулах буюу шалгалт хийх (§234);
- өргөдлийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээн ил тод байдлыг хангах (§235);
- иргэдийн өргөдөл, санаачилгыг авч хэлэлцэх (§236).

1.3. Байнгын хорооны бүрэлдэхүүн

1.3.1. Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим)

ӨБХ найман гишүүнээс бүрдэх бөгөөд тэднээс тав нь эрх баригч намын, гурван нь Засгийн газрын бус (сөрөг хүчний/бие даагч) гишүүдээс сонгогдоно (Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэгийн §220(b)).

1.3.2. Их Британи Улс (Нийтийн Танхим)

ӨБХ хамгийн ихдээ 11 гишүүнтэй байна (Нийтийн Танхимын хуралдааны дэгийн §145A(2)). Гишүүдийг Засгийн болон сөрөг хүчний намуудаас сонгох бөгөөд бүрэлдэхүүнийг Нийтийн Танхим дахь нийт суудалтай хувь тэнцүүлэн тогтооно (Parliament & UK Government, n.d.).

1.3.3. Герман Улс (Бундестаг)

ӨБХ-нд тогтсон гишүүдийн тоо байхгүй. ӨБХ-ны бүрэлдэхүүнийг парламент дахь бүлгүүдийн суудлын тоонд хувь тэнцүүлсэн байдлаар хуваарилна (Бундестагийн хуралдааны дэгийн §12).

Гишүүдийг бүлгүүд томилдог. Харин намд харьяалагдаагүй гишүүдийг Бундестагийн Ерөнхийлөгч санал хэлэх эрхтэй боловч саналын эрхгүйгээр ӨБХ-нд орж болно (§57). 2025 оны байдлаар ӨБХ нь 26 гишүүнтэй байна (German Bundestag, n.d.-2).

1.3.4. Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс)

ӨБХ-ны гишүүдийг парламент дахь бүлгүүдийн санал болгосноор Төлөөлөгчдийн Конгрессын дарга баталгаажуулж, олон нийтэд зарлана. Тэднийг бүлгүүдийн суудлын тоонд хувь тэнцүүлсэн байдлаар хуваарилна (Төлөөлөгчдийн Конгрессын хуралдааны дэгийн §40.1-2).

ӨБХ-ны удирдах бүтэц (Mesa) нь дарга, хоёр дэд дарга, хоёр нарийн бичгээс бүрдэнэ (§41.1).

1.3.5. Европын Холбоо (Европын Парламент)

Европын Парламентын хуралдааны дэгт ӨБХ-ны гишүүдийн тоог тогтоогоогүй боловч бүрэлдэхүүнийг бүлгүүдийн суудлын тоонд хувь тэнцүүлсэн байдлаар хуваарилна. Мөн гишүүдийг сонгохдоо жендэрийн тэнцвэрийг хангах шаардлагатай (§216.2).

Бүлгүүд хоорондоо тохиролцож ӨБХ-ны бүрэлдэхүүнийг бүрдүүлнэ. Хэрэв тохиролцоонд хүрээгүй бол асуудлыг хурлын дарга шийдвэрлэнэ. Хэрэв бүлэг хугацаандаа нэр дэвшигчээ оруулаагүй бол тухайн суудал хоосон үлдэнэ, өөр бүлгийн гишүүнээр нөхөхийг хориглодог (§216.3).

ХОЁР. ӨРГӨДӨЛ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦ БА ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ

2. Өргөдлийн төрөл, түүнд тавигдах шаардлага

2.1. Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим)

Төлөөлөгчдийн Танхимд өргөдлийг цаасан (paper petitions), эсхүл цахим (e-petitions) хэлбэрээр гаргах бөгөөд аль аль нь Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэгд заасан шаардлагыг хангасан байна.

Өргөдөлд дараах нийтлэг шаардлагыг тавина (§204):

- Төлөөлөгчдийн Танхимд хаяглагдсан байх;
- Төлөөлөгчдийн Танхимын эрх хэмжээний хүрээний асуудлыг хөндсөн байх;
- үндэслэл, хүсэлтээ тодорхой бичсэн байх;
- зохистой хэл найруулгатай байх;
- англи хэлээр бичсэн байх (эсхүл баталгаат орчуулгатай байх);
- 250 үгээс хэтрэхгүй байх;
- хууль бус үйлдэл сурталчлаагүй байх;
- нэмэлт баримт бичиг хавсаргаагүй байх;
- цахим холбоос (URL) агуулаагүй байх.

- Цаасан өргөдлийн хувьд (§205):
  - нүүр хуудсанд өргөдөл гаргагчийн (хэрэв хамтарч өргөдөл гаргаж байгаа бол үндсэн өргөдөл гаргагчийн) овог нэр, хаягийг бичсэн байх;
  - өргөдөл гаргагч (үндсэн өргөдөл гаргагч) нь нүүр хуудсанд гарын үсгээ өөрийн гараар зурсан байх (гарын үсгийг хэвлэх, наахыг хориглоно);
  - үндсэн өргөдөл гаргагчаас бусад этгээдийн “үл хангасан гарын үсэг”-ийг хасч болох ч энэ нь өргөдлийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй;
  - хуулийн этгээдийн хувьд байгууллагын тамга дарсан байх.

- Цахим өргөдлийн хувьд (§205A):
  - өргөдөл гаргагч овог нэр, хаягаа бүртгүүлэх;
  - англи хэлээр бичсэн байх;
  - өргөдлийг Төлөөлөгчдийн Танхимын цахим хуудас (https://www.aph.gov.au/e-petitions)-д бүртгэснээс хойш дөрвөн долоо хоногийн турш гарын үсэг цуглуулах;
  - нийтлэгдсэний дараа өргөдлийн нөхцөлийг өөрчлөхгүй.

2.1.1. Их Британи Улс (Нийтийн Танхим)

Нийтийн Танхимын хуралдааны дэгийн 145A дугаар зүйлд заасны дагуу өргөдлийг цаас хэлбэрээр, эсхүл цахимаар хүлээн авна.

- Бүх хэлбэрийн өргөдөлд дараах нийтлэг шаардлагыг тавьдаг (UK Parliament, 2025-1); (UK Parliament, 2025-2):
  - тодорхой үйлдэл шаардаж, агуулга нь ойлгомжтой, давхардаагүй байх;
  - шүүхээр хэлэлцэж буй маргаанд хамаарахгүй байх;
  - улс төрийн намтай холбоотой, төрийн нууц, гүтгэлэг, худал мэдээлэл агуулаагүй байх;
  - хэл найруулга нь зохистой, хүндэтгэлийн өнгө аястай байх;

- англи хэлээр бичсэн байх (эсхүл өргөдөл гаргагчийн зөв гэж баталгаажуулсан орчуулгыг хавсаргасан байх).

- Цаасан өргөдөлд тавигдах шаардлага (UK Parliament, 2025-1):
  - нүүр хуудаст өргөдлийн бүтэн эх бичвэр, өргөдөл гаргагчийн овог нэр, хаягийг бичсэн байх;
  - гарын үсгийг өргөдөл гаргагч нь өөрийн гараар зурсан байх;
  - хуулбар болон цахим гарын үсгийг хүлээн зөвшөөрөхгүй;
  - хаяг, гарын үсэг нь өргөдөл гаргагчийн тодорхойлолттой таарч байх;
  - бичвэрт (баллаж) засвар хийгээгүй байх.

- Цахим өргөдөлд тавигдах шаардлага (UK Parliament, 2025-2):
  - өргөдөл гаргагч нь Их Британи Улсын иргэн, эсхүл тус улсад оршин суугч байх;
  - Нийтийн Танхим, эсхүл Засгийн газрын эрх, чиг үүрэгт шууд хамаарсан байх;
  - тодорхой үйлдэл шаардаж, агуулга нь ойлгомжтой, давхардаагүй байх;

Цахим өргөдлийг Парламент, Засгийн газрын цахим систем (https://petition.parliament.uk) дээр зургаан сарын турш нээлттэй байна (UK Parliament, 2025-3).

Хэрэв цахим өргөдөл 10,000 гарын үсгийн дэмжлэг авбал Засгийн газар бичгээр албан ёсны хариу өгч, уг хариуг олон нийтэд нээлттэй нийтэлдэг (Parliament & UK Government, n.d.). Харин 100,000 болон түүнээс дээш гарын үсэг цугларсан бол ӨБХ уг өргөдлийг Нийтийн Танхимаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Энэ нь заавал хэлэлцэнэ гэсэн үг биш бөгөөд хэлэлцэх эсэх нь ӨБХ-ны бүрэн эрхийн хүрээнд шийддэг (Parliament & UK Government, n.d.).

2.1.2. Герман Улс (Бундестаг)

“Өргөдлийн байгын хорооны хүсэлт, гомдлыг шийдвэрлэхэд баримтлах зарчим (Процессын зарчим)”-д өргөдлийг дараах байдлаар ангилдаг (§2.2). Үүнд:

- олон дахин гаргасан өргөдөл - ижил асуудлаар тус бүр бие даан бичсэн өргөдлүүд;
- хамтын өргөдөл - ижил асуудлаар олон хүний гарын үсэг цуглуулсан өргөдөл;
- олонхын өргөдөл - ижил асуудлаар олон хүнээс ирүүлсэн бөгөөд бичвэр нь бүхэлдээ, эсхүл үндсэндээ ижил өргөдөл;
- олон нийтийн өргөдөл - нийтийн ашиг сонирхолд хамаарах өргөдөл бөгөөд өргөдөл гаргагчийн зөвшөөрлөөр нийтлэгдэж, бусад иргэд түүнийг дэмжих буюу хэлэлцүүлэгт оролцох боломжтой.

Хамтын болон олон нийтийн өргөдөл нийтлэгдсэн өдрөөс хойш зургаан долоо хоногийн дотор 30,000 болон түүнээс дээш хүний дэмжлэг авбал ӨБХ нээлттэй сонсгол зохион байгуулж хэлэлцэнэ (§8.4.1). 2024 оны 7 дугаар сараас өмнө уг босго 50,000 байсан бөгөөд дэмжлэг цуглуулах хугацаа дөрвөн долоо хоног байсныг ийнхүү сунгажээ (German Bundestag, 2024).

Мэдээлэл авах хүсэлт, эсхүл мэдэгдэл, зааварчилгаа, буруутгал, хүлээн зөвшөөрөлт зэрэг нь өргөдөлд тооцогдохгүйг “Процессын зарчим”-д тодорхой заасан (§2.3).

Өргөдлийн хэлбэрт тавигдах шаардлага (§4). Үүнд:

- өргөдлийг бичгээр гаргах бол өргөдөл гаргагчийн гарын үсэгтэй байх;
- цахимаар гаргасан бол өргөдөл гаргагчийн нэр, шуудангийн хаягийг тодорхой бичиж, цахим өргөдлийн зориулалтын маягтыг ашигласан байх (энэ нь цахим гарын үсгийн орлуулалт гэж тооцно);
- амаар илэрхийлсэн өргөдлийг хүлээн авахгүй.

Олон нийтийн өргөдөлд тусгай шаардлага тавьдаг. Тухайлбал, өргөдөл гаргаж буй тухайн асуудал нь нийтийн ашиг сонирхлыг хөндөж, тодорхой хувь хүмүүст хамаарахгүй байх бөгөөд олон нийтийн бодит хэлэлцүүлэгт тохирохуйц тодорхой, ойлгомжтой, үндэслэлтэй байхыг “Процессын зарчим”-д шаарддаг (Хавсралт 7.1 (4)-ийн §2.1).

Олон нийтийн өргөдлийг хүлээн авахгүй байх тохиолдлууд (Хавсралт 7.1 (4)-ийн §3):

- нийтийн ашиг сонирхлын асуудлыг хөндөөгүй бол;
- хувийн хүсэлт, гомдлыг агуулсан бол;
- герман хэлээр бичээгүй бол;
- хүний нэр төрийг зөрчсөн бол;
- илт худал, гуйвуулсан, доромжлол бүхий агуулгатай бол;
- илт хамааралгүй, эсхүл таамаглалд тулгуурласан бол;
- эрүүгийн болон захиргааны зөрчил өөгшүүлсэн, Үндсэн хууль ба ёс суртахууны хуулийг зөрчсөн бол;
- хүний хувийн эрхийг зөрчсөн, хамгаалагдсан мэдээлэл агуулсан, арилжааны бүтээгдэхүүн, үйл явцыг сурталчилсан, эсхүл бусад сурталчилгаа агуулсан бол;
- цахим холбоос (URL) агуулсан бол;
- парламентын нэр төрд үл нийцэх үг хэллэг хэрэглэсэн бол.

2.1.3. Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс)

Төлөөлөгчдийн Конгрессын хуралдааны дэгийн 49 дүгээр зүйлд зааснаар өргөдлийг иргэн, бүлэг, холбоо, эсхүл хуулийн этгээдээс хүлээн авна.

Өргөдөл гаргах эрхийг зохицуулах хуулийн 4 дүгээр зүйлд өргөдөлд дараах үндсэн шаардлагыг заасан байна (§4). Үүнд:

- өргөдлийг бичгээр гаргах;
- өргөдөл гаргагчийн овог нэр, гарын үсэг болон оршин суугаа газрын хаягийг тодорхой бичсэн байх;
- өргөдлийн агуулга нь хууль бус, доромжлолын шинжтэй үг хэллэг агуулаагүй, үндсэн эрх, эрх чөлөөг зөрчөөгүй байх;
- хамтын өргөдлийн хувьд бүх өргөдөл гаргагчийн гарын үсгийг хавсаргах;
- өргөдөл нь эрх бүхий байгууллага, хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг байгууллагад хандсан байх;
- өргөдөл нь шүүхийн хэрэг маргааныг шийдвэрлэх зорилготой байж үл болно.

2.1.4. Европын Холбоо (Европын Парламент)

Европын Парламентын хуралдааны дэгийн 232 дугаар зүйлд өргөдөл гаргах эрх болон хамрах хүрээг тодорхойлсон байдаг. Тус зүйлд зааснаар Европын Холбооны иргэн, гишүүн улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа бие хүн, мөн гишүүн улсад бүртгэлтэй хуулийн этгээд нь дангаар болон бусадтай хамтран Европын Парламентад өргөдөл гаргах эрхтэй (§232.1).

Өргөдлийг шуудангаар, эсхүл Европын Парламентын цахим портал ашиглан гаргаж болно (§232.7). Өргөдөл нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна. Үүнд:

- өргөдөл нь Европын Холбооны үйл ажиллагааны хүрээнд хамаарч, өргөдөл гаргагчид шууд нөлөөлсөн асуудлыг тусгасан байх (§232.1);
- өргөдөл гаргагчийн нэр, байнгын оршин суугаа хаягийг тодорхой бичсэн байх (§232.2);

- өргөдөл нь Европын Холбооны албан ёсны хэлээр бичсэн байх, хэрэв өөр хэлээр бичсэн бол орчуулгыг хавсаргах (§232.6).

2.2. Өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх үйл явц

2.2.1. Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим)

ӨБХ нь өргөдлийг дараах үе шаттайгаар хүлээн авч шийдвэрлэхийг Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэгд зохицуулсан байдаг. Үүнд:

- өргөдөл хүлээн авах (§206(a))
    - цаасан өргөдлийг ӨБХ-нд шууд, эсхүл гишүүнээр дамжуулан өргөн мэдүүлнэ;
    - цахим өргөдлийг албан ёсны цахим хуудас (https://www.aph.gov.au/e-petitions)-аар дамжуулан өргөн мэдүүлнэ;
- урьдчилсан шалгалт хийх (§206(b))
    - ӨБХ-оос өргөдлийн шаардлага хангаж байгаа эсэхийг шалгана;
- Төлөөлөгчдийн Танхимд танилцуулах (Australian Parliament, 2025-2) -
    - ӨБХ-ны дарга өргөдөл болон байнгын хорооны тайланг Даваа гарагийн “Хороо, төлөөлөгчдийн үйл ажиллагаа” (Committee and delegation business) хэсэгт 10 минутаас ихгүй хугацаанд танилцуулна. Танилцуулгад өргөдлийн агуулга, дэмжигчдийн (гарын үсгийн) тоог тусгана (§207(a));
    - ӨБХ-ны гишүүн дэгийн §207(b)-д заасан боломжит үеэр өргөдлийг танилцуулж болно: гишүүний мэдэгдэл (§43), сонгуулийн тойргийн мэдэгдэл (§193), хуралдаан завсардуулах үеийн хэлэлцүүлэг (§31; 191), гомдлын хэлэлцүүлэг (§192B);
- нийтлэх (§208(d))
    - Төлөөлөгчдийн Танхимд танилцуулсан өргөдлийг Hansard[11]-д нийтэлнэ;
- сайд/яаманд шилжүүлж, хариу авах (§209(a)-(c))
    - ӨБХ өргөдлийг холбогдох сайд, эсхүл яаманд шилжүүлж болно;
    - сайд, эсхүл яамнаас 90 хоногийн дотор хариуг бичгээр ирүүлнэ;
    - хариуг ӨБХ-ны дарга танилцуулж, Hansard болон Парламентын цахим хуудаст нийтэлнэ;
- хариу өгөх (§208(d))
    - ӨБХ өргөдөлд Төлөөлөгчдийн Танхимын өмнөөс хариу өгнө.

2.2.2. Их Британи Улс (Нийтийн Танхим)

Нийтийн Танхимын дэгийн дагуу цаасан өргөдлийг Нийтийн Танхимд дараах хоёр хэлбэрээр өргөн мэдүүлдэг:

---

[11] Төлөөлөгчдийн Танхимын “Hansard” гэснийг Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэгийн 45 дугаар зүйлд “...Төлөөлөгчдийн Танхимын байнгын хороо, дэд хороо, Төлөөлөгчдийн Танхим болон Сенатын хамтарсан хорооны баримт бичиг, тайлан, Парламентын тайлангийн ажилтны яамны бэлдсэн нотлох баримтыг хэвлэх эрх бүхий байгууллага ...” гэж тодорхойлсон байна. Хандах: *https://www.aph.gov.au/-/media/05_About_Parliament/53_HoR/532_PPP/Standing_Orders/SOs_as_at_23_July_2025.pdf*

- албан ёсны танилцуулга - өргөдлийг өдрийн хуралдааны төгсгөлд танилцуулдаг. Тодруулбал, Даваа гарагт 22:00, Мягмар ба Лхагва гарагт 19:00, Пүрэв гарагт 17:00 цагт танилцуулна (§153; 154). Энэ үед гишүүн тухайн өргөдөл гаргагчийн нэр, гарын үсгийн тоо, гол агуулгыг товч танилцуулж, өргөдөлд туссан хүсэлтийг уншаад эхийг бичээчид хүлээлгэн өгнө (§153; 154);
- албан бус танилцуулга - өргөдлийг хуралдааны аль ч үед бичгээр “илтгэгчийн суудлын ард байрлах ногоон уут”-нд хийх хэлбэрээр өргөн мэдүүлж болно. Энэ тохиолдолд гишүүн танилцуулага хийхгүй, хүлээлгэн өгдөг. Үүнийг дэгд зохицуулаагүй ч Парламентын өргөн хэрэглэгддэг тогтсон практик юм (UK Parliament, 2025).

Цахим өргөдлийн хувьд, ӨБХ эхлээд өргөдлийн шаардлага хангасан эсэхийг шалгана. Шаардлага хангаж буй өргөдлийг Парламентын цахим хуудас (https://petition.parliament.uk)-д нийтэлж, гарын үсэг цуглуулах үйл явц эхэлдэг (§145A).

Өргөдлийг дараах байдлаар хянан шийдвэрлэнэ (UK Parliament, 2025-2). Үүнд:

- өргөдлийг Нийтийн Танхимд танилцуулсны дараагийн өдөр Hansard-д нийтэлнэ (§156);
- өргөдлийг холбогдох яаманд хүргүүлж, улмаар сайд нарын бичгээр өгсөн албан ёсны хариу тайлбар (ministerial observations) ирүүлснийг мөн нийтэлнэ (§156);
- ӨБХ өргөдлийг хянан үзэж, нотолгоо шаардах, өргөдөл санаачлагч болон иргэдтэй уулзалт, сонсгол зохион байгуулах, холбогдох яамдаас тайлбар авах зэрэг арга хэмжээг авна (§145A);
- ӨБХ шаардлагатай гэж үзвэл өргөдлийг Вестминстерийн танхимд хэлэлцүүлэх шийдвэр гаргаж болно. Өргөдлийн хэлэлцүүлэг нь Даваа гараг бүр 16:30-19:30 цагийн хооронд явагдах бөгөөд энэ тогтмол хугацааг ӨБХ шийдвэрлэнэ (§10.1(a)).

2.2.3. Герман Улс (Бундестаг)

“Өргөдлийн байгын хорооны хүсэлт, гомдлыг шийдвэрлэхэд баримтлах зарчим (Процессын зарчим)”-д зааснаар өргөдлийг бичгээр, эсхүл цахим тусгай маягтаар (https://epetitionen.bundestag.de/) хүлээн авч (§4), дараах журмаар хянан үзнэ. Үүнд:

- урьдчилсан шалгалт хийх
  - өргөдөл шаардлага хангасан эсэхийг урьдчилан шалгана (§4; Хавсралт 7.1 (4)-ийн §5);
  - өргөдлийн төрлийг тогтооно: олон дахин гаргасан өргөдөл, хамтын өргөдөл, олонхын өргөдөл, эсхүл олон нийтийн өргөдөл (§2.2);
  - ижил төстэй өргөдлийг нэгтгэж, тэргүүлэх өргөдөл гаргагчийг тогтоон, бусдыг нь “дэмжигч” гэж тооцно (Процессын зарчмын Хавсралт 7.1 (4)-ийн §2.2);
- хянан шалгах, хэлэлцүүлэх
  - өргөдөл санаачлагч, холбогдох талууд, яам болон бусад байгууллагаас санал, тайлбар, баримт нотолгоо авч, тэдэнтэй зөвлөлдөнө (§7.7);
  - ӨБХ өргөдлийг хэлэлцэж, шийдвэр болон зөвлөмж гарган Бундестагт танилцуулна (Дэгийн §112; Процессын зарчмын §7.6-8; 8.6.1);
- холбогдох талуудад мэдээлэх

- өргөдөл гаргагчид болон холбогдох талуудад шийдвэрийн үр дүн, зөвлөмж, Бундестагийн хэлэлцүүлгийн үр дүн зэргийг мэдээлнэ (§9; §9.1 Benachrichtigung der Petenten)

Олон нийтийн өргөдөлд тусгай шаардлагыг тавьдаг: асудал нь нийтийн ашиг сонирхолд хамаарах, бодитой, тодорхой, ойлгомжтой, мөн үндэслэлээр баталгаажсан байх ёстой (Хавсралт 7.1 (4)-ийн §2.1).

Дараах тохиолдолд өргөдлийг хүлээн авахаас татгалзана (Хавсралт 7.1 (4)-ийн §4; 5):

- тухайн ӨБХ-ийн бүрэн эрхийн хугацаанд ижил асуудлаар аль хэдийн шийдвэр гаргасан бөгөөд шинэ нөхцөл байдал гараагүй бол;
- ижил асуудлаар өргөдөл аль хэдийн парламентын хяналтад байгаа бол;
- нийгмийн энх тайван, олон улсын харилцаа, соёл хоорондын яриа хэлэлцээнд сөргөөр нөлөөлөх магадлалтай бол;
- өргөдөл гаргагч өмнө нь ижил асуудлаар олон нийтийн өргөдөл нийтлүүлсэн бол.

2.2.4. Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс)

Өргөдөл гаргах эрхийг зохицуулах хуулийн дагуу иргэн, бүлэг, холбоо, эсхүл хуулийн этгээд нь төрийн аливаа байгууллага, түүнчлэн Төлөөлөгчдийн Конгресс, Сенат болон Автономит улсуудын хууль тогтоох байгууллагад өргөдөл гаргах эрхтэй (§1).

Төлөөлөгчдийн Конгресст өргөдлийг дараах журмаар хянан үзнэ:

- урьдчилан шалгах - ӨБХ өргөдлийг шалгаж, хэлэлцээд, шаардлагатай гэж үзвэл нэмэлт баримт бичиг шаардах, холбогдох байгууллага, албан тушаалтнаас тайлбар авах, эсхүл өргөдөл гаргагчийг сонсох арга хэмжээ авна (Дэгийн §49);
- шийдвэр гаргах - ӨБХ өргөдлийн агуулгаас хамааран дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргана (Дэгийн §50) -
  - өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргах;
  - холбогдох байгууллагад шилжүүлэх;
  - Төлөөлөгчдийн Конгрессоор хэлэлцүүлэхийг санал болгох;
- хэлэлцүүлэх - ӨБХ-оос гаргасан “санал, дүгнэлтийн нэгдсэн жагсаалт”-ыг Төлөөлөгчдийн Конгресс хэлэлцэж шийдвэрлэнэ (Дэгийн §194);
- мэдэгдэх - ӨБХ эцсийн шийдвэр, санал, дүгнэлтийг өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэнэ (хуулийн §11).

2.2.5. Европын Холбоо (Европын Парламент)

Европын Парламентын хуралдааны дэгийн 232 дугаар зүйлд өргөдөл гаргах хэлбэрийг тодорхой заасан байдаг. Үүнд: өргөдлийг шуудангаар гаргах эсвэл Европын Парламентын цахим өргөдлийн портал (https://www.europarl.europa.eu/petitions/en/home) ашиглан гаргаж болно (§232.7).

Дэгийн дагуу Европын Парламент өргөдлийг дараах журмаар хүлээн авч, хянан үзнэ:

- өргөдөл хүлээн авах, бүртгэх
  - өргөдлийг бүртгэлд дараалаар оруулах ба шаардлага хангаагүй бол буцаана (§232.9);
  - ижил агуулгатай хэд хэдэн өргөдлийг хамтад нь авч үзэж болно (§232.8);

- өргөдлийн хамтран гаргагчид төлөөлөгч, орлогч томилно, томилоогүй бол эхний гарын үсэг зурсан хүнийг төлөөлөгчөөр тооцно (§232.4);

- шаардлага хангасан эсэхийг тогтоох
  - бүртгэгдсэн өргөдлийг Европын Парламентын Ерөнхийлөгчөөс ӨБХ-нд шилжүүлж, байнгын хороо нь шаардлага хангасан эсэхийг тогтооно (§232.10);
  - зөвшөөрөгдөөгүй өргөдлийг хадгалж, шалтгааныг өргөдөл гаргагчид мэдэгдэнэ. Ингэхдээ, өргөдөл гаргах өөр гарц гаргалгааг санал болгож болно (§232.11);

- өргөдлийг хэлэлцэх
  - зөвшөөрөгдсөн (admissible) өргөдлийг ӨБХ-ны хуралдаанаар, эсхүл бичгээр хэлэлцэнэ (§233.1);
  - өргөдөл гаргагчийг ӨБХ-ны хуралдаанд урьж болох бөгөөд үг хэлэх эрхийг даргалагчийн үзэмж (discretion)-ээр олгоно (§233.1);
  - ӨБХ өргөдлийн талаар товч тогтоолын төсөл боловсруулж, Европын Парламентад өргөн мэдүүлэх эрхтэй. Энэ нь найман долоо хоногийн дотор хэлэлцэх асуудлын жагсаалтад багтаж, нэг удаагийн санал хураалтаар шийдвэрлэгдэнэ (§233.2);
  - ӨБХ Европын Холбооны Комиссоос мэдээлэл, баримт авч болно. Мөн Комиссын төлөөлөгчдийг хуралдаанд урьж оролцуулж болно (§233.5);
  - ӨБХ Комисс, Зөвлөл, эсхүл гишүүн улсын байгууллагад санал, зөвлөмж хүргүүлж болно (§233.6);

- шийдвэрлэх ба тайлагнах
  - ӨБХ жил бүр өргөдлийн хэлэлцүүлгийн үр дүнгийн талаар Европын Парламентад тайлагнаж, дууссан өргөдлийг хаасан гэж зарлана (§233.7);
  - ӨБХ өргөдлийг олонхын саналаар шийдвэрлэнэ (§233.10);
  - өргөдөл гаргагчид ӨБХ-оос гаргасан шийдвэр, түүний үндэслэлийг мэдээлнэ (§233.8);
  - шинэ баримт гарвал өргөдлийг дахин сэргээж болно (§233.9);

- баримт тогтоох айлчлал хийх - ӨБХ зөвшөөрөгдсөн, хуралдаанд аль хэдийн хэлэлцсэн өргөдлийн хүрээнд баримт тогтоох, шийдэл эрэх зорилгоор холбогдох гишүүн улс, эсхүл бүс нутагт баримт тогтоох шалгалт (fact-finding visits)-ыг зохион байгуулж болно (§234):
  - баримт тогтоох шалгалтыг хийх гишүүн нь тухайн улсын төлөөлөгч байж болохгүй. Гэхдээ тэд дагалдах (ex officio) байдлаар шалгалтад оролцож болох хэдий ч тайлан боловсруулах, үнэлэх үйл явцад оролцохгүй;
  - төлөөлөгчдийн ахлах нь айлчлалын тайланг нэгтгэж, зөвшилцөлд хүрэхийг эрмэлзэнэ.Хэрэв зөвшилцөлгүй бол санал зөрөлдсөн дүгнэлтүүдийг тусгана;
  - айлчлалын гишүүд тайланг хэлэлцэн батална;
  - батлагдсан тайланг Европын Парламентын Ерөнхийлөгчид мэдээлэх танилцуулах зорилгоор илгээнэ;

- өргөдлийн талаарх мэдэгдэл (§235)

- Европын Парламент нь шаардлага хангасан өргөдлийн бүртгэл, мөн тухайн өргөдөлд дагаж мөрдөх журам (цаашид хэрхэн авч үзэх, хаах, шилжүүлэх гэх мэт)-ын гол шийдвэрүүдийг олон нийтэд мэдэгдэнэ. Энэ мэдэгдэл нь Парламентын хуралдааны тэмдэглэлд үлдэх бөгөөд өргөдлийн гарчиг ба хураангуй, түүнтэй холбоотой дүгнэлтүүдийн бүрэн бичвэр, мөн өргөдөлтэй холбоотой чухал шийдвэрүүдийг Парламентын вэбсайтын Өргөдлийн портал дээр олон нийтэд нээлттэй байршуулна.

2.3. Олон нийтийн оролцоог хангах

2.3.1. Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим)

Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэгд зааснаар ӨБХ өргөдлийн агуулгатай холбоотойгоор нэмэлт мэдээлэл шаардах, сонсгол зохион байгуулах, өргөдөл гаргагч болон мэргэжилтнүүдийг оролцуулах бүрэн эрхтэй (§208(c)).

Өргөдлийн ил тод байдлыг дараах байдлаар хангадаг. Үүнд:

- шаардлага хангасан өргөдлийг Төлөөлөгчдийн Танхимд танилцуулсны дараа албан ёсны тэмдэглэл болох Hansard-д нийтэлдэг (§208(d));
- сайд, эсхүл яамнаас ирүүлсэн өргөдлийн хариуг мөн Hansard болон Парламентын цахим хуудаст нийтэлдэг (§209(c));
- цахим өргөдөл нь бүртгүүлснээс хойш дөрвөн долоо хоногийн дотор урьдчилсан шалгалт хийсний дараа Төлөөлөгчдийн Танхимын цахим хуудсанд нийтлэгдэж, олон нийт гарын үсгээр дэмжих боломжтой (§205A), (Australia Parliament, n.d.);
- цахим өргөдлийг Төлөөлөгчдийн Танхимын өргөдлийн систем (https://www.aph.gov.au/e-petitions)-д нийтэлж, гарын үсэг цуглуулах явцыг олон нийтэд нээлттэй байршуулдаг.

2.3.2. Их Британи Улс (Нийтийн Танхим)

Нийтийн Танхимын дэгийн дагуу ӨБХ өргөдлийг нийтлэгдсэний дараа хянан үзэж, санаачлагчдыг хэлэлцүүлэгт урих, нотолгоо цуглуулах уулзалт зохион байгуулах, яамдад бичгээр шаардлага илгээх, бусад байнгын хороодод шилжүүлэх, шаардлагатай тохиолдолд Вестминстерийн танхимд хэлэлцүүлэг товлодог (§145.3, 4, 5) (Parliament & UK Government, n.d.).

2.3.3. Герман Улс (Бундестаг)

Олон нийтийн өргөдлийг цахим системд нийтэлснээс хойш зургаан долоо хоногийн дотор олон нийтийн хэлэлцүүлгээр нээлттэй хэлэлцэгдэнэ. Хэрэв өргөдлийг дэмжсэн хүний тоо 30,000-д хүрвэл нээлттэй сонсгол зохион байгуулж, өргөдөл гаргагчийг заавал оролцуулна (German Bundestag, n.d.-4).

Мөн Процессын зарчимд зааснаар олон нийтийн өргөдлийн үр дүнг Бундестагийн өргөдлийн системд нийтэлж, олон нийтийн сонсголыг шууд дамжуулан, дараа нь бичлэгээр үзэх боломжийг олгодог (§10). ӨБХ эцсийн шийдвэр гаргасны дараа өргөдөл гаргагчид хэлбэр, үндэслэлийг бичгээр мэдэгдэнэ. Бундестаг урт хугацааны завсарлага хийх тохиолдолд өргөдөл гаргагчид түр мэдэгдэл (Ferienbescheid) илгээх зохицуулалттай (§9).

2.3.4. Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс)

Хэрэв ӨБХ нь өргөдлийг бусад байгууллагууд руу шилжүүлэн өгөх нь зүйтэй гэж үзвэл Төлөөлөгчдийн Конгрессын даргаар дамжуулан бусад байнгын хороо руу, мөн Омбудсмен (Defensor del Pueblo), Засгийн газар, Сенат, шүүх, прокурор, орон нутгийн байгууллагууд руу уламжилж болно (§49.2). Эсхүл өргөдөл нь шаардлага хангагдаагүй гэж үзвэл тухайн өргөдлийг бусад байгууллага руу шилжүүлэлгүйгээр хэрэгсэхгүй болгож болно (§49.3).

ӨБХ нь аливаа өргөдөл хүлээн авсныг баталгаажуулж, хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргасан ч заавал өргөдөл гаргагчид албан ёсоор мэдэхийг хуульчилсан байна (§49.3-4).

2.3.5. Европын Холбоо (Европын Парламент)

Европын Парламентын дэгийн дагуу өргөдлийн портал дээр иргэд өргөдлийг дэмжих, эсхүл дэмжсэн шийдвэрээ буцаах боломжтой (§233.4). Өргөдөл гаргагч хүссэн үедээ гарын үсгээ буцаах боломжтой бөгөөд бүх гарын үсэг буцаагдвал өргөдөл хүчингүйд тооцогдоно (§232.5).

Өргөдлийн ил тод байдлыг хангах зохицуулалтад:

- бүртгэгдсэн өргөдөл олон нийтэд ил тод баримт бичигт тооцогдож, өргөдөл гаргагч, хамт өргөдөл гаргагч, дэмжигчдийн нэр болон өргөдлийн агуулгыг Европын Парламент нийтэлж болно (§232.12);
- өргөдөл гаргагч, хамт өргөдөл гаргагч, дэмжигч нар нэрээ нууцлах хүсэлт гаргавал Европын Парламент уг хүсэлтийг хүндэтгэнэ (§232(13));
- гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах зорилгоор Парламент өөрийн санаачилгаар, эсхүл тэдний хүсэлтээр өргөдөл болон бусад мэдээллийг нууцалж болно (§232.14).

ӨБХ санал, дүгнэлт, гол шийдвэр, авсан арга хэмжээ, жил бүрийн тайланг өргөдлийн портал дээр нийтэлж олон нийтэд танилцуулдаг (§233.5, §233.7). Мөн байнгын хороо бүх шийдвэр болон тэдгээрийн үндэслэлийг өргөдөл гаргагчид мэдээлэх үүрэгтэй (§233.8).

ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Өргөдлийн эрхийг Үндсэн хуулийн түвшинд Герман, Испани, Их Британи (1689 оны Bill of Rights), Европын Холбоо (гэрээнүүд) баталгаажуулсан бол Австрали Улсад тусгаагүй, зөвхөн парламентын дэг ба уламжлалаар хэрэгждэг. Судалгаанд хамрагдсан бүх улсад болон Европын Холбоонд Өргөдлийн байнгын хороо (ӨБХ)-г байгуулах, түүний эрх, үүрэг, үйл ажиллагааг парламентын дэгээр нарийвчлан зохицуулдаг байна. Зарим тохиолдолд тусгай хууль (Испани - Өргөдөл гаргах эрхийг зохицуулах хууль; Герман - Өргөдлийн байнгын хорооны хүсэлт, гомдлыг шийдвэрлэхэд баримтлах зарчим), эсхүл бодлогын баримтаар (Австрали, Их Британи) баталгаажуулсан байна. Ийнхүү эрх зүйн үндэс харилцан адилгүй боловч нийтлэг шинж чанар нь өргөдлийг парламентын институцийн түвшинд холбон бэхжүүлж, иргэдийн оролцоог хангах албан ёсны механизм болгон хөгжүүлжээ.

ӨБХ-дын эрх, үүргийн зохицуулалтыг харьцуулан судлахад, бүх байнгын хороодын нийтлэг шинж нь өргөдөл хүлээн авч хэлэлцэх, тайлагнах чиг үүрэг бол; ялгаатай тал нь - Их Британи, Герман, Испанид хяналт, мэдээлэл шаардах эрх нь өргөн хүрээтэй байхад Европын Парламент олон нийтийн оролцоо, ил тод байдал, баримт тогтоох шалгалт зэргийг илүү өргөн хүрээтэй эрх, үүрэг болгож төлөвшүүлэн хөгжүүлсэн байна.

ӨБХ-ны бүрэлдэхүүнийг тогтоохдоо нийтлэг зарчим нь парламент дахь бүлгүүдийн суудлын харьцаанд хувь тэнцүүлсэн төлөөлөл юм. Австралид (8 гишүүн), Их Британид (дээд тал нь 11 гишүүн) тогтсон тоо заасан бол Герман, Европын Парламентын хувьд тогтсон тоо байхгүй байна. Испани Улсад бүрэлдэхүүнийг бүлгүүдийн санал болгосноор баталгаажуулж, удирдлагын тусгай бүтэц (Mesa) хуульчилсан. Европын Парламент жендэрийн тэнцвэрийг хангахыг шаарддаг онцлог зохицуулалттай байна.

Өргөдөлд тавигдах шаардлагын зохицуулалт улс орон бүрд ялгаатай боловч нийтлэг зарчим нь тодорхой хэлбэр, хэл найруулга, эрх хэмжээний хүрээ, хууль ёсны үндэслэлтэй холбоотой байна. Мөн гарын үсэг болон хувийн мэдээллийг тодорхой бичихийг шаардаж байна. Герман Улс олон нийтийн өргөдлийг тусгайлан ялгаж, дэмжлэгийн босго тогтоож, нийтийн ашиг сонирхолд нийцсэн байхыг онцолдог бол Европын Парламент өргөдлийг зөвхөн холбооны үйл ажиллагааны хүрээнд, албан ёсны хэл дээр, нэр хаяг тодорхой тусгасан тохиолдолд зөвшөөрдөг.

Өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх үйл явц улс бүрд харилцан адилгүй зохицуулагддаг ч нийтлэг зарчмаараа тодорхой үе шаттайгаар хэрэгждэг. Австрали, Их Британи, Испанид урьдчилсан шалгалт хийж, өргөдлийг парламентын хуралдаанд танилцуулан холбогдох байгууллагад шилжүүлэх, эсхүл байнгын хорооны хэлэлцүүлэгт оруулах тогтолцоотой. Герман Улс олон нийтийн өргөдөлд тусгай шалгуур тавьж, шаардлагатай дэмжлэг авсан тохиолдолд нээлттэй сонсгол явуулах бөгөөд байнгын хорооны гаргасан шийдвэр, зөвлөмжийг Бундестагт танилцуулдаг. Европын Парламент өргөдлийг бүртгэж, шалгуур хангасан эсэхийг тогтоон, хорооны хуралдаанаар хэлэлцэж, Комисс болон бусад байгууллагаас мэдээлэл авч, жил бүр тайлагнахын зэрэгцээ баримт тогтоох шалгалт зохион байгуулах хүртэл өргөн хүрээтэй ажиллагаа явуулдаг байна.

Ийнхүү өргөдөл шийдвэрлэх үйл явцын нийтлэг зарчим нь: урьдчилсан шалгалт хийх, танилцуулах/нийтлэх, хэлэлцэх, холбогдох байгууллагад шилжүүлэх/тайлагнах, өргөдөл гаргагчид мэдээлэх гэсэн шатлалтай хэрэгждэг бөгөөд улс бүр энэ зарчмыг өөрийн хууль эрх зүйн онцлогт тохируулан тусгажээ.

Олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах зохицуулалтыг харьцуулбал, дараах нийтлэг болон онцлог шинжүүд ажиглагдана. Австрали, Их Британи, Герман Улс өргөдлийг нийтэд ил тод болгохын тулд Hansard болон цахим системээр нийтэлж, өргөдөл гаргагчийг

сонсгол, хэлэлцүүлэгт оролцуулах, олон нийт гарын үсгээр дэмжих боломж олгодог. Германд тодорхой босго болох 30,000-с олон хүн өргөдлийг дэмжсэн тохиолдолд заавал нээлттэй сонсгол явуулдаг нь иргэдийн оролцоог хангах сайн жишиг арга хэмжээ юм. Испанид өргөдлийг олон түвшний байгууллагад уламжлах боломжийг хуульчилсан бөгөөд өргөдөл хэрэгсэхгүй болсон ч өргөдөл гаргагчид заавал мэдэгддэг нь ил тод байдлын баталгаа болдог. Европын Парламентын хувьд өргөдлийг дэмжих, буцаах, нэрээ нууцлах, эсвэл мэдээллийг нууцлах боломж олгосноор иргэдийн эрхийг хамгаалж, өргөдлийн портал дээр гол шийдвэр, тайлангаа нийтлэх замаар ил тод байдлыг хэрэгжүүлдэг.

Ингэснээр бүх тогтолцоонд өргөдөл нь зөвхөн албан ёсны баримт бус, олон нийтийн дэмжлэг, хяналт, оролцооны чухал хэрэгсэл болж буйг харуулж байна.

НОМ ЗҮЙ

UK Parliament. (2015 оны October 20). *e-Petitions. House of Commons Library.* https://commonslibrary.parliament.uk/research-briefings/sn06450/?utm-ээс гаргасан

Erskine May. (2019). *Petitions Committee.* Erskine May: Parliamentary Practice online: https://erskinemay.parliament.uk/section/5962/petitions-committee/?utm-ээс Гаргасан

Parliament & UK Government. (n.d.). *How petitions work.* https://petition.parliament.uk/help-ээс гаргасан

European Parliament. (2025). *Briefing: The Right to Petition the European Parliament.* https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2025/767225/EPRS_BRI%282025%29767225_EN.pdf?utm-ээс гаргасан

Australia Parliament. (n.d.). *Learn About Petitioning.* https://www.aph.gov.au/Parliamentary_Business/Petitions/House_of_Representatives_Petitions/Learn?utm-ээс гаргасан

UK Parliament. (2025). *How to present a paper petition formally. MPs' Guide to Procedure.* https://guidetoprocedure.parliament.uk/articles/x2XCEOCd/how-to-present-a-paper-petition-formally-ээс гаргасан

German Bundestag. (2024 оны June 26). *Petitionsausschuss senkt Quorum für öffentliche Anhörung von 50.000 auf 30.000 Mitzeichnungen.* https://www.bundestag.de/dokumente/textarchiv/2024/kw26-pa-petitionen-quorum-1010108-ээс гаргасан

German Bundestag. (n.d.-1). *23. Mai 1949: Parlamentarischer Rat verkündet das Grundgesetz.* Deutscher Bundestag: https://www.bundestag.de/dokumente/textarchiv/1949-05-23-grundgesetz-641776?utm-ээс гаргасан

German Bundestag. (n.d.-2). *Petitions Committee.* https://www.bundestag.de/en/committees/a02-ээс Гаргасан

German Bundestag. (n.d.-4). *Öffentliche Petitionen.* https://epetitionen.bundestag.de/epet/service.$$$.rubrik.oeffentlichePetition.html-ээс гаргасан

UK Parliament. (2025-1). *Rules for paper petitions. In MPs' Guide to Procedure.* https://guidetoprocedure.parliament.uk/articles/o6p31XXN/rules-for-paper-petitions-ээс гаргасан

UK Parliament. (2025-2). *Rules for e-petitions. MPs' Guide to Procedure.* https://guidetoprocedure.parliament.uk/articles/KTEOVTHF/rules-for-e-petitions-ээс гаргасан

UK Parliament. (2025-3). *E-petitions: overview. MPs' Guide to Procedure.* https://guidetoprocedure.parliament.uk/articles/7KsdfkXF/e-petitions-overview-ээс гаргасан

Australian Parliament. (2025-2). *House of Representatives Practice, Chapter 17: Petitions.* https://www.aph.gov.au/About%20Parliament/House%20of%20Representatives/Powers%20practice%20and%20procedure/Practice7/HTML/Chapter17/7chap17_2_7.html#_ftnref285-ээс гаргасан

Australian Parliament. (2025-1 оны July 23). *Petitions. In House of Representatives Practice (7th ed.).* https://www.aph.gov.au/About%20Parliament/House%20of%20Representatives/Powers%20practice%20and%20procedure/Practice7/HTML/Chapter17/7chap17_2_7.html#_ftnref285 -ээс гаргасан

Parliamentary Education Office. (n.d.). *Petitions.* PEO: https://peo.gov.au/understand-our-parliament/having-your-say/getting-involved/petitions-ээс гаргасан

UK Parliament. (n.d.). *Bill of Rights 1689.* Parliament.uk: https://www.parliament.uk/about/living-heritage/evolutionofparliament/parliamentaryauthority/revolution/collections1/collections-glorious-revolution/billofrights-ээс гаргасан

UK Parliament. (n.d.). *Layout of Hansard.* Guide to Procedure: https://guidetoprocedure.parliament.uk/articles/i2NRtojY/layout-of-hansard-ээс гаргасан